

Монгол Улсын Их хурлын гишүүн, Сангийн сайд Ч.Улаан Баян-Олгий аймагт ажиллалаа.

Тэрбээр очигдор 21:00 цагт Толбо сумын иргэд, ходалморчидтэй уулзалт хийсэн бол оноодор 10:00 цагаас аймгийн Засаг даргын Тамгын газрын Хурлын танхимд аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар болон албан газрын дарга, эрхлэгч нартай уулзалт хийж, аймгийн Засаг дарга Х.Дармений “Баян-Олгий аймгийн оноогийн байдал, цаашдын хөгжлийн хандлагын тухай”, Санхүү, торийн сангийн хэлтсийн дарга Б.Шолпаны “Баян-Олгий аймгийн Тосов, санхүүгийн талаархи товч танилцуулга” мэдээллийг сонсож, харилцан санал солилцлоо.

Сангийн сайд уулзалтын дараа аймгийн Татварын хэлтэс, Гаалийн газрын ажил байдалтай танилцав.

Дараа нь “Хөгжимт драмын театр”-т Баян-Олгий аймгийн ард иргэдтэй Сангийн сайд уулзалт хийж, Шинэчлэлийн Засгийн газрын бодлого, шийдвэр, вйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, иргэдийн сонирхсон асуултад хариулт өглоо.

### **Тус аймгийн Хөдөө аж ахуйн салбарын одоогийн нөхцөл байдал**

1. 2013 онд зуны улирал нэлээд тааламжтай, бороо хур элбэг, бэлчээр, хадлангийн ургац сайтай жил болсон. Зун, намартаа тарга хвч сайн авсан мал сүрэг онд сайн орж байна.

2. 2013 оны эцэст аймгийн дүнгээр 1 сая 604 мянган толгой мал тоо тоологдсон. Мал аж ахуйн голлох салбар нь уламжлалт бэлчээрийн мал аж ахуй бөгөөд зонхилох хэсгийг бог мал эзэлдэг.

3. Тус онд 685,000 толгой хээлтэгч толлох бөгөөд малын ид толлолтийн хугацаа 3-р сарын 5-аас эхлэх юм. Мал сүрэгт ямар нэгэн халдварт овчин гараагүй, тайван байна.

4. Мал аж ахуйг эрчимжүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах, малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх зэрэг нь тус салбарын гол анхаарах хандуулах асуудал болж байгаа.

5. Газар тариалан эрхлэх асуудал тус аймгийн хувьд хязгаарлагдмал боловч оноогийн түвшингээс бууруулахгүйгээр ургацын гарцыг нэмэгдүүлэх замаар хүн амыг оорийн томс хүнсний ногоогоор хангах зорилт тавин ажиллаж байна.

### **Уул уурхайн салбарын одоогийн нөхцөл байдал**

1. Одоогийн байдлаар аймагт гянт болдын олборлолт эрхэлдэг “СС Монголия” ХХК, Кайнар вольфром ХХК-д, нүүрсний Хотгор ХХК идэвхитэй вйл ажиллагаа явуулж байгаа богоод аймагт зэс, хар тугалга баяжуулах Дулаан харын вйлдвэр ашиглалтанд орж удахгвй нээлтээ хийх гэж байна. Уг вйлдвэр ашиглалтанд орсноор шинээр 600 ажлын байр бий болох боломж гарч байна.

2. Тус аймагт стратегийн ач холбогдол бvхий Асгатын монгоний орд, Хох адарийн холимог металлийн орд, Алтай сумын Даваатын болон Булган сумын Жаргалантын алтны ордууд, Толбо сумын Улаан хатуугийн онгот металлийн орд, Улаанхус сумын нуурын голын гянт болдын, Ногооннуур сумын Цvнхэгийн гянт болдын, Бор хагийн зэс молибдений орд, Алтанцогцийн Цагаан хадын алтны орд, Цэнгэл сумын Бор бургасын гянт болдын ордууд нарийвчилсан хайгуулын ажил хийгдсэн ашиглахад бэлэн байна.

### **Аж вйлдвэрийн салбарын одоогийн нөхцөл байдал**

1. Аймагт Аватекс Хайнар ХХК-ны ноос угаах, самнах, боловсруулах вйлдвэр ажиллаж байгаа богоод бvтээгдэхvнээ Европд экспортолдог. Баруун 3 аймгийн хонь, тэмээний ноосыг тус вйлдвэр цуглуулан боловсруулалт хийдэг. Нийт 400 орчим ажлын байрыг бий болгож байгаа.

2. Мал нядлах, мах боловсруулах 5 вйлдвэр байдаг ба тус онд малын гоц халдварт шvлхий овчин гарсантай холбоотой тvр ажиллахгвй байна.

3. Жилд 300 мянган тн цемент вйлдвэрлэх хvчин чадал бvхий цементийн вйлдвэр баригдаж тус 2014 онд ашиглалтанд ороход бэлэн болж байна.

4. 2013 онд сэндвичэн хавтан вйлдвэрлэх 2 вйлдвэр шинээр ашиглалтанд орсон

5. Барилгын ханын материал болон хаалга цонх вйлдвэрлэх 10-аад жижиг дунд вйлдвэр ажиллаж байна.

### **Баян-Өлгий аймгийн Санхvв төсвийн нөхцөл байдал**

1. Аймгийн 2014 оны Орон нутгийн төсвийн зарлага 17667.0 сая тогрог, төсвийн орлого 4837.6 сая тогрог, Орон нутгийн хогжлийн сангийн шилжvвлэг 10328.9 сая тогрог, Тусгай зориулалтын шилжvвлгээр санхvвждэг байгууллагуудын төсов 40412.3 сая тогрогээр батлагдсан

2. 2013 оны байдлаар төсвийн байгууллагууд 90,0 сая тогрогийн оглогтэй гарч /1 сарын халаалтын холс ороогvй/жилийн эцэст улсын төсов, тусгай зориулалтын шилжvвлгээр санхvвждэг байгууллагуудын дансны влдэгдэл 307.1 сая тогрогийг тов

торийн санд товлорчлолсон.

3. Аймгийн арилжааны банкуудын жилийн эцсийн зээлийн үлдэгдэл 96.2 тэрбум тогрог, үүнээс хугацаа хэтэрсэн зээл 1354.0 сая, чанаргүй зээлийн үлдэгдэл 548.0 сая, иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 50991.0 сая тогрог байна.

4. Аймгийн арилжааны банкууд 2013 онд 7623.0 сая тогрогийн ашигтай ажилласан.

5. 2013 онд аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангаар 2250,0 сая тогрогийн, ЖДҮДСангаар 500,0 сая тогрогийн хонгололттэй зээл олгогдсон.

6. Аймгийн төвийн төсвийн байгууллагуудын халаалтыг 8 сар болгосон шийдвэр гарсан боловч 2014 оны сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын байгууллагуудын төсөв 7 сараар батлагдсан байна.

7. Уулын бүсэд оршдог тус аймгийн хувьд намар эрт эхэлж хавар уртасдаг ба 2013 онд цаг агаарын ноцол байдлаас шалтгаалж аргагүйн эрхэнд 15 хоног халаалт огсон. Үүнээс болж 135.7 сая тогрогийн оглог гарч байна.

8. Цаашид энэ асуудлыг анхаарч сургууль, цэцэрлэг, эмнэлгийн халаалтын хугацааг 8 сар болгон уртасгах зайлшгүй шаардлагатай байна.